

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/129/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
Байхгүй	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ЖАРМАНГУЛ ТАНАА**

2022.02.25 № 186
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Өлгий-ЕБ-ын-8-dugnelt

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Өлгий-ЕБ-ын-8-dugnelt

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4389517.00</u>	<u>3629017.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4389517.00	3629017.00
354	Хангамжийн материал	4389517.00	3629017.00
35420	Аж ахуйн материал	2533400.00	2533400.00
35440	Түлш, шатах тослох материал	760500.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	1095617.00	1095617.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60142947.35</u>	<u>59489966.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60142947.35	59489966.83
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	59595547.35	58942566.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	38185614.00	38185614.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1199220.38	-2566360.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24336715.00	27986715.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14563197.81	-16535833.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9648644.00	9648644.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5462015.21	-6044415.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	3312050.00	3312050.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2001516.25	-2382321.25
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	7338474.00	7338474.00
393	Биет бус хөрөнгө	547400.00	547400.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	547400.00	547400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>64532464.35</u>	<u>63118983.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1181482.00</u>	<u>0.00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1181482.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>63350982.35</u>	<u>63118983.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	63350982.35	63118983.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37821898.00	37821898.00
51101	Өмч: - төрийн	37821898.00	37821898.00
512	Хуримтлагдсан үр дүн	14985923.63	14753925.11
51210	Өмнөх үеийн үр дүн	14985923.63	14985923.63
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-231998.52
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10543160.72	10543160.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>64532464.35</u>	<u>63118983.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	224,750,876.00	210,107,713.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,539,200.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,539,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	223,211,676.00	210,107,713.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,456,076.00	199,514,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	15,593,176.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	201,862,900.00	199,514,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,407,013.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,407,013.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,755,600.00	6,186,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,755,600.00	6,186,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	213,091,628.79	210,339,711.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,091,628.79	210,339,711.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,307,028.79	198,475,690.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,015,210.00	161,611,310.00
210101	Үндсэн цалин	146,492,351.00	142,049,678.00
210104	Урамшуулал	8,522,859.00	11,575,432.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,986,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,489,624.00	19,380,500.00
210201	Тэтгэврийн даатгал	19,488,824.00	13,638,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	800.00	1,435,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,148,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	286,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,871,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,419,600.00	6,446,900.00
210301	Гэрэл, цахилгаан	84,500.00	874,400.00

210302	Түлш, халаалт	2,173,400.00	3,572,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,161,700.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,932,300.00	3,735,100.00
210401	Бичиг хэрэг	190,800.00	79,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,920,000.00	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	695,000.00
210404	Ном, хэвлэл	142,800.00	114,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,056,100.00	346,000.00
2105	Нормативт зардал	451,100.00	261,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,500.00	33,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,600.00	228,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	314,800.00	91,300.00
210702	Дотоод албан томилолт	314,800.00	91,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	1,164,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	764,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,234,394.79	5,284,880.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,300.00	981,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,500,094.79	4,302,980.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,784,600.00	11,864,021.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,880,900.00	7,303,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,880,900.00	7,303,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,802,200.00	4,561,021.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,802,200.00	4,561,021.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101,500.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,659,247.21	(231,998.52)

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,659,247.21	(231,998.52)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,985,923.63		63,350,982.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,985,923.63	0	63,350,982.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,985,923.63	0	63,350,982.35
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,985,923.63	0	63,350,982.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,985,923.63	0	63,350,982.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-231,998.52		-231,998.52
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,821,898.00	10,543,160.72	14,753,925.11	0	63,118,983.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	207618500.00	210107713.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	207618500.00	210107713.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	201862900.00	199514300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	201862900.00	199514300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4407013.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4407013.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5755600.00	6186400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5755600.00	6186400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	206768500.00	206457713.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206768500.00	206457713.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	182983900.00	194593692.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151615800.00	162792792.00
210101	Үндсэн цалин	130637740.00	143231160.00
210104	Урамшуулал	16440260.00	11575432.00
210105	Гэрээт ажлын хөлс	4537800.00	7986200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19461500.00	19380500.00
210201	Тэтгэврийн даатгал	13695300.00	13638500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1441300.00	1435400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1153300.00	1148600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	288300.00	286900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2883300.00	2871100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5654100.00	5686400.00
210301	Гэрэл, цахилгаан	688000.00	874400.00
210302	Түлш, халаалт	2674400.00	2812000.00
210303	Цэвэр, бохир ус	2291700.00	2000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3717700.00	3735100.00
210401	Бичиг хэрэг	230800.00	79900.00
210402	Тээвэр, шатахуун	1920000.00	2400000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622600.00	695000.00
210404	Ном, хэвлэл	167900.00	114200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		100000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	776400.00	346000.00
2105	Нормативт зардал	870900.00	261500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31500.00	33100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	839400.00	228400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500000.00
210604	Урсгал засвар		500000.00
2107	Томилолт, зочны зардал	314800.00	91300.00
210702	Дотоод албан томилолт	314800.00	91300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450000.00	1164200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		764200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	400000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	899100.00	981900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	899100.00	981900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23784600.00	11864021.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1880900.00	7303000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1880900.00	7303000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21802200.00	4561021.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21802200.00	4561021.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101500.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101500.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	850000.00	3650000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	850000.00	3650000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	850000.00	3650000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	850000.00	3650000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-850000.00	-3650000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	205700700.00	201146692.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205700700.00	201146692.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198397700.00	193843692.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164517500.00	162792792.00
210101	Үндсэн цалин	144846600.00	143231160.00
210104	Урамшуулал	10595300.00	11575432.00
210105	Гэрээт ажлын хөлс	9075600.00	7986200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22209800.00	19380500.00
210201	Тэтгэврийн даатгал	15629200.00	13638500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1645200.00	1435400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1316100.00	1148600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	329000.00	286900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3290300.00	2871100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5686400.00	5686400.00
210301	Гэрэл, цахилгаан	874400.00	874400.00
210302	Түлш, халаалт	2812000.00	2812000.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	2000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3635100.00	3635100.00

210401	Бичиг хэрэг	79900.00	79900.00
210402	Тээвэр, шатахуун	2400000.00	2400000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695000.00	695000.00
210404	Ном, хэвлэл	114200.00	114200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	346000.00	346000.00
2105	Нормативт зардал	261500.00	261500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33100.00	33100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	228400.00	228400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
2107	Томилолт, зочны зардал	91300.00	91300.00
210702	Дотоод албан томилолт	91300.00	91300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	514200.00	514200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114200.00	114200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	981900.00	981900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	981900.00	981900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7303000.00	7303000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7303000.00	7303000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	205700700.00	201146692.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	199514300.00	194960292.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	199514300.00	194960292.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6186400.00	6186400.00
132001	Орон нутгийн төсвөөс	6186400.00	6186400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.0	21.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	4400000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4400000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	4400000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	100000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		100000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	4300000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4300000.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7013.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		7013.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	4407013.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4407013.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4407013.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус сургууль нь 2021 оны хичээлийн жилд " Хүүхэд нэг бүрийг хөгжиж төлөвших эрүүл таатай орчин бүрдүүлэх эвсэг бүтээлч хамт олон болох" зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд 2019,2020 оны материалын шалгалт хийгдсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй боловч захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 213.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.4 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0	0.00	0.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	4389.5	3629.0	-760.5
Үндсэн хөрөнгө	60142.94	59489.96	-652.98
Нийт хөрөнгө	64532.5	63118.9	-1413.6
Өр төлбөр	1181.5	0	-1181.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	63350.9	63118.9	-232.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	64532.5	63118.9	-1413.6

Бараа материал дансны үлдэгдэл 3.6 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 2.4 сая төгрөгийн материал худалдан авч, 3.2 сая төгрөгийн материал зарцуулж, түлш шатах тослох материал дансны үлдэгдэл 0.8 сая төгрөгийг зарцуулсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 59.5 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 4.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 63.1 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 0.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 210.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 14.7 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй бараа материал авсан, тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт авсантай холбоотой нэмэлт санхүүжилтийн орлого материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад урсгал шилжүүлгээс төвлөрүүлэх шилжүүлэг зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2020 оны анх батлагдсан төсөв 181.7 сая төгрөг, тодотгосон төсөв 205.7 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 24.0 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үүнд: Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 21.6 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал үдийн цайны зардалыг 0.5 сая төгрөгөөр хассан тодотгол хийгдсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 24.5 сая төгрөгөөр дутуу суулгасан, нэмэгдэл, урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь тайлант онд 205.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 201.1 сая төгрөгийг зарцуулж, төсвийг нийт дүнгээр 4.5 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 201.1 сая төгрөг буюу 97.7 хувьтай байна.

Нийт төсвийн 81 хувийг цалин, 9.6 хувийг НДШ-ийн зардал, 2.8 хувийг тогтмол зардал, 1.8 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.2 хувийг урсгал засварын зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.6 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч хангамж, бараа материалын зардалд 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд 4.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 162.8 сая төгрөг, НДШ-ийн зардалд 19.4 сая төгрөг, халаалтын зардалд 5.7 сая

төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 0.5 сая төгрөг, үдийн цайны зардалд 7.3 сая төгрөг нийтдээ 195.7 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн орлого болох 205.7 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 195.7 сая төгрөгийг хасахад 10.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.0 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна. Тус сургууль оны эцэст 4.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2021 онд нийт 201.1 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 201.1 төгрөгийн 122 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 26 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан зөрчилд 1 зөвлөмж, интернетийн төлбөр, усны үнэ, томилолтын мөнгө зэрэгт зарцуулсан нийт 3.4 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд шилэн дансны зөвлөмж өгсөн зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2021 онд нийт 201.7 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 201.7 сая төгрөгийн 122 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын дундаж 81 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”; 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн мэдээ, мэдээллийг хугацаандаа байршуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль	1	0					1	0		